



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2018 оны 09 сарын 10 өдөр

Дугаар А/39

Мандалговь

Г Байгууллагын хөдөлмөрийн дотоод
журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Хөдөлмөрийн тухай хуулийн 130 дугаар зүйлийн 130.2, Засгийн газрын 2018 оны 8 дугаар сарын 22-ны өдрийн “Төрийн албаны сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай” 258 дугаар тогтоолын 1, Засаг даргын Тамгын газрын даргын 2017 оны 10 дугаар сарын 19-ний өдрийн А/161 дүгээр тушаалаар баталсан “Дундговь аймгийн Засаг даргын Тамгын газрын хөдөлмөрийн дотоод журам”-ын 31.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

Нэг. Аймгийн Засаг даргын Тамгын газрын хөдөлмөрийн дотоод журмын 25 дугаар зүйлд дор дурьдсан агуулгатай дараах 25.5 дахь заалт нэмсүгэй. Үүнд:

25.5. Ажлын байрандаа согтууруулах ундаа, мансууруулах бодис, галт болон хүйтэн зэвсэг, тэсэрч дэлбэрэх болон шатамхай бодис, хэрэгслийг нэвтрүүлэх, хадгалах, хэрэглэх, ашиглахгүй байх;

Хоёр. Хөдөлмөрийн дотоод журмын 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

25.1. Албан томилолтын явцад, ажлын болон ажлын бус цагаар ажлын байранд согтууруулах ундаа хэрэглэхгүй байх;

Гурав. Дээрх хоёр заалтыг үйл ажиллагаандаа мөрдэж, хэрэгжүүлж байгууллагын ажилтан, албан хаагч наарт үүрэг болгосугай.

Дөрөв. Тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын хэлтсийн дарга наарт даалгасугай.

ДАРГА

Ц.ЭРДЭНЭСҮРЭН

438000273